



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2022 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 09

Чингис хот

Г Хурдан морины үр алдаан сунгаан,
үсэргээнд хяналт тавих тухай

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусlamж дэмжлэг үзүүлэх тухай журам”, “Үндэсний морин уралдааны уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага” MNS 6264:2018 стандартыг тус тус үндэслэн ДААЛГАХ нь:

1. Сумдын Засаг дарга, тосгодын захирагч наарт Нийгмийн бодлогын хэлтсээс 2022 оны 5 дугаар сарын 25-ны 2/1334, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 2022 оны 6 дугаар сарын 24-ний 204 албан бичгээр тус тус хүргүүлсэн чиглэл болон хурдан морины уралдаан сунгаан, үсэргээн зохион байгуулахад хүүхдийн эрхийг хангаж, хамгаалалтын хувцас өмсүүлэх, уралдааны зам, хүүхдийн насны онцлогт ахадсан дээд насны морьд унуулахгүй байх, уралдаан зохион байгуулагч тал хариуцлагатай байх чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг зохион байгуулж, тайлан мэдээллийг 2022 оны 8 дугаар сарын 30-д Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт ирүүлэхийг сумдын Засаг дарга наарт, ирүүлсэн тайлан мэдээг нэгтгэн, дүгнэж аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлэхийг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийг газарт тус тус даалгасугай.

Сумдын Засаг дарга буюу Хамтарсан багийн ахлагч наарт:

1. Сум, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулагдах наадам, үсэргээ, сунгаанд хяналт тавих чиг үүрэг бүхий салбар дундын ажлын хэсэг байгуулж, хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах

2. Үндэсний морин уралдааны уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS 6264:2018 стандартыг мөрдүүлэх, уралдаанч хүүхэд бүрд шаардлага хангасан хувцас, хэрэгсэл өмсгэх

3. Хурдан морины уралдаанч хүүхдийн бүртгэлийг бүрэн хийж, гэнэтийн ослын даатгалд хамруулах

4. Овоо, тахилга, сургууль, цэцэрлэгийн ой, үсний даахь, үргээх ёслолын үед морь уралдуулах зөвшөөрөл олгохгүй байх

5. Хэт халуун наортай эсвэл дуу цахилгаантай, хүчтэй аадар бороотой, зам халтираатай үед хурдан морины уралдааны товыг хойшлуулах, цуцлах арга хэмжээ авч ажиллах

6. Эцэг эх, асран хамгаалагч, узач зохион байгуулагчдын хариуцлагыг өндөржүүлж, мэдээ, мэдээллээр хангах, хууль тогтоомжийг таниулан сурталчилж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах

2.

7.Хурдан морь унаач хүүхдэд өгөх бэлгийг сонгохдоо хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүнсний бүтээгдэхүүн (бохь, чипс, хийжүүлсэн ундаа, будагтай чихэр гэх мэт) өгөхгүй байх

8.Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Өнөрцэцэг), зохион байгуулсан ажил, арга хэмжээ, гарсан үр дүнг аймгийн хэмжээнд нэгтгэн, 2022 оны 8 дугаар сарын 30-д Хүүхдийн төлөө зөвлөлд тайлагнахын Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Х.Уртнасан)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

